



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/795

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмэгтэйчүүдийн умайн хүзүүний оношилгоог сайжруулах зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай хиймэл оюун ухааны ServiCare Ai оношилгооны аппаратыг 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр "Эй Ай Меди Монголиа" ХХК-тай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, хүлээн авахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ